



**НИЙСЛЭЛИЙН БАЯНГОЛ ДҮҮРГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2021 оны 03 сарын 05 өдөр

Дугаар А/82

Улаанбаатар хот

“Баянгол-Сууц өмчлөгчдийн холбоо  
ба иргэдийн оролцоо” дэд хөтөлбөр боловсруулах  
ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.1.5.”д” дэх заалт, Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 3/03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Баянгол-Сууц өмчлөгчдийн холбоо ба иргэдийн оролцоо” дэд хөтөлбөрийн төсөл боловсруулах Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:

Эдийн засаг, худалдаа үйлчилгээ, тохижилт, нийтийн аж ахуйн асуудал хариуцсан төслийн удирдагч

Гишүүд:

ТНААХ-ийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

ТНААХ-ийн Агаар орчны бохирдол, гадна тохижилтын тасгийн дарга

ТНААХ-ийн Тохижилт, ногоон байгууламж хариуцсан мэргэжилтэн

ТНААХ-ийн Агаар орчны бохирдол, гадна тохижилтын тасгийн Хог хаягдал, агаарын бохирдол, гэр хорооллын дэд бүтцийн хөгжил хариуцсан ажилтан

ТНААХ-ийн Байгууллагын гадна тохижилт, хаяг, гадна зар сурталчилгаа хариуцсан ажилтан

Монголын Сууц өмчлөгчдийн холбооны Дээд зөвлөлийн Баянгол салбар зөвлөлийн тэргүүлэгч (зөвшилцсөнөөр)

Баянгол дүүргийн Сууц өмчлөгчдийн холбооны Нэгдсэн зөвлөлийн Удирдах зөвлөлийн дарга (зөвшилцсөнөөр)

ТНААХ-ийн ОСНААҮ, СӨХ хариуцсан мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга:

ТНААХ-ийн ОСНААҮ, СӨХ хариуцсан мэргэжилтэн

2. Дэд хөтөлбөрийн төслийг холбогдох хууль, журмын дагуу боловсруулан 2021 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн дотор Засаг даргын Зөвлөлийн хуралд танилцуулахыг (Ажлын хэсэг)-т даалгасугай.

3. Ажлын хэсгийг удирдлага, арга зүйгээр хангаж ажиллахыг Эдийн засаг, худалдаа үйлчилгээ, тохижилт, нийтийн аж ахуйн асуудал хариуцсан төслийн удирдагч (Д.Мөнхбаатар)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ө.СУМЪЯАБААТАР